

## МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТ, ЧИГ ХАНДЛАГА

*Жеоффри Хэйс (Ph.D), НҮБХАС-ын техникийн зөвлөх*

Эдийн засгийн хөгжлийн үр дүнд урт хугацааны хүн амын өөрчлөлт бий болж байдаг ба энэхүү өөрчлөлтийг дэлхийн ихэнх улс орон дагадаг. Нэг хүнд ногдох орлого бага үед төрөлт, нас баралтын түвшин өндөр, хүн амын өсөлт бага байдаг бол орлого өсөх үед хүн амын амьдралын түвшин дээшилж, нас баралтын түвшин буурах ба төрөлтийн түвшин өндөр хэвээр хадгалагдсаны улмаас хүн ам эрчимтэй өсөж эхэлдэг. Эцэст нь төрөлтийн түвшин буурч нас баралтын түвшиний бууралтын доод түвшинд дөхөж очих ба эргээд хүн амын өсөлт доогуур түвшинд очдог. Хүн амзүйн энэхүү өөрчлөлтийг “хүн ам зүйн шилжилт” гэдэг. Европын улсуудад хүн ам зүйн шилжилт эхэлснээс хойш 200 жил гаруй хугацаанд үргэлжилсэн бол Азийн улс орнуудад хүн ам зүйн шилжилт илүү богино хугацаанд буюу ойролцоогоор 50-60 жилийн хугацаанд явагдаж байна.

Монгол Улсын хүн ам зүйн өөрчлөлт, чиг хандлагыг харахад хүн ам зүйн шилжилтийн ерөнхий хэв маягийг дагаж байгаа хэдий ч Монгол Улсын улс төр, эдийн засгийн амьдралтай холбоотой бий болсон зарим нөхцөл байдал хүн ам зүйн өөрчлөлтийн онцлог шинжийг харуулж, бусад улс оронтой харьцуулахад амаргүй болгож байна. Хүн амаа анх тоолсон 1918 оноос 1950 оны дунд үе хүртэлх хугацаанд нас баралтын түвшин өндөр, төрөлтийн түвшин доогуур байснаас Монгол Улсын хүн амын өсөлт доогуур (жилийн 1 хувиас бага) түвшинд байсан. 1950 оны сүүл үеэс хүн амын өсөлт хурдсаж, 1969-1979 онд хамгийн оргил үедээ хүрчээ. Бусад улс орны адилаар 1960, 1970-аад оны Монгол Улсын хүн амын хурдан өсөлт төрөлтийн түвшний өсөлт, нас баралтын түвшний бууралттай холбоотой байлаа. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн “Хүн амыг өсгөх” бодлого төрөлтийг өндөр түвшинд хүргэж, улмаар хүн амын өсөлт

эрчимжсэн. 1980-оноос энэхүү бодлогын эрч суларч, хүн амын дундах төрөлтийн түвшин буурч эхэлсэн. 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш төрөлтийн түвшин огцом буурч, нас баралт нэмэгдэж мөн олон тооны хүн гадаад руу шилжсэн. Энэ бүхний үр дүнд 1990-ээс 2005 оны хооронд хүн амын өсөлт удааширсан. Нэг эмэгтэйд ногдох хүүхдийн тоо 2005 онд хамгийн доогуур түвшинд 1.95-д хүрсэн. 2000-2010 оны хоорондох хүн амын тооллогоор Монгол Улсын хүн амын өсөлтийн дундаж хурд 1.1 болж буурчээ.

1918 оноос хойшхи Монгол Улсын хүн ам зүйн түүхэн хандлагаас харвал хүн ам зүйн шилжилтийн 3 үе шатыг туулжээ. 1) хүн амын амьжиргааны түвшин доогуур байсантай холбоотой хүн амын өсөлт бага байсан үе; 2) хүн амын амьжиргааны түвшин, амьдралын чанарын дээшлэлттэй холбоотой хүн амын хурдацтай өсөлтийн үе; 3) эдийн засгийн хөгжил эрчимжиж, орлого өссөнөөс хүн амын өсөлт удааширсан үе. Хүн ам зүйн шилжилтийн 2-р үе шатны Монгол Улсын хүн ам хурдацтай өсөлт зөвхөн нас баралтын бууралт биш мөн төрөлтийн өсөлттэй холбоотой байсан нь бусад улс орноос онцлог ялгаатай шилжилт явагдсаныг харуулж байгаа юм. Цаашлаад, хүн ам зүйн шилжилтийн 3-р үед хүн амын өсөлтийн хурд буурсан нь эдийн засгийн өсөлтийн үр дүн биш харин зах зээлийн эдийн засагт шилжсэн үеийн эдийн засгийн хямралтай илүү холбоотой байсан. Энэ үед Монголын гэр бүлүүд эдийн засгийн байдлаа сайжиртал хүүхэд төрүүлэхээ хойшлуулах эсвэл зогсоох арга хэмжээ авч байсан.

2005 оноос хойш, Монгол Улсад төрөлтийн түвшин эргээд өссөн ба 2005 оны түвшнээс гуравны нэгээр нэмэгдэж 2011 онд нэг эмэгтэйд дунджаар 2.6


хүүхэд ногдох болсон байна. Ингэснээр Монгол Улсын төрөлтийн түвшин Тайланд, Сингапур, Солонгос улсууд шиг “төрөлтийн хэт доогуур” түвшинд хүрэхгүй болсон. Өнөөгийн байдлаар Монгол Улс хүн ам зүйн шилжилтийн 4-р үе шатанд буюу төрөлтийн бага түвшнээс төрөлт нэмэгдэж байгаа үед явж байна. Төрөлтийн түвшний энэхүү өсөлтийн шалтгааныг тодорхой судалсан зүйл хараахан байхгүй байна. Зарим ажиглагчид 2006 онд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн “хүүхдийн мөнгө” хөтөлбөр гол шалтгаан болсон гэж үзэж байгаа юм. Зарим нь эдийн засгийн хямралын үед олон гэр бүл төрөлтөө хойшлуулж, сүүлийн арваад жилийн туршид эдийн засгийн нөхцөл байдлаа илүү тайтай болохыг хүлээж байсан төрөлт одоо явагдаж байгаа хэмээн үзэж байна. Энэ шалтгааны аль аль нь үнэний ортой байх талтай. Хэдийгээр хүн амын өсөлтийн хурд сүүлийн 100-аад жилийн туршид өсөж, буурч давалгаалсан хандлагатай байсан хэдий ч хүн ам цаашид үргэлжлэн нэмэгдэхээр байна. 1918 онд 647,500 байсан хүн ам 2010 оны хүн ам орон сууцны тооллогоор 2 саяар нэмэгдэж 2,647,500 болжээ. Энэ нь хүн ам жилд дунджаар 1.5 хувиар өсөж байсныг харуулж байгаа юм. Сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдсэнээс 2011 онд хүн амын жилийн дундаж өсөлт 1.9 хувь болж, 2000-2010 оны түвшнээс нэмэгдсэн байна.

Монгол Улсын хүн амын ирээдүйн төлөв байдлыг бодитоор урьдчилан харах

боломжгүй ч Үндэсний Статистикийн газраас 2010 оны хүн ам орон сууцны тооллогын мэдээн дээр үндэслэсэн хийсэн хэтийн тооцоогоор хүн амын тоо 2017 онд 3.0 сая, 2040 онд 4.0 сая орчимд хүрэхээр байна. Хэрэв төрөлтийн түвшин одоогийн түвшинд хадгалагдаж чадвал хэтийн тооцоо хийсэн хугацаанаас илүү хурдан хугацаанд хүн ам 3,0 сая, 4,0 саяд хүрэх юм. Өөр нэгэн тодорхойгүй хүчин зүйл нь эрэгтэй хүн амын дундах нас баралтын түвшин. Өнөөгийн байдлаар эрэгтэй хүн амын дундаж наслалт эмэгтэй хүн амаас 7.4 насаар бага (эрэгтэй хүн амын дундаж наслалт 64.9, эмэгтэй хүн амынх 72.3) байна. Үүний гол шалтгаан нь насанд хүрсэн эрэгтэй хүн амын дундах нас баралтын өндөр түвшин юм. Хэрэв эрэгтэй хүн амын дундах нас баралтын түвшинг бууруулж чадвал хүн амын ирээдүйн өсөлтөд бага ч болов нөлөө үзүүлэх болно.

Монгол Улсын хүн амын сүүлийн 10 жилийн хүн амын өсөлт, бууралтын өөрчлөлт нь хүн амын насны бүтэцтэй холбоотой. 1990-ээд оны төрөлтийн түвшний огцом бууралт нь 0-14 насны хүүхдийн хүүхдийн тоо бага байхад нөлөөлсөн. Үүнийг хүн амын нас хүйсний бүтцийн суврагаас (Зураг 1) харж болохоор байна. 2005 оноос хойшхи төрөлтийн өсөлтийг 5-9 насныхнаас илүү 0-4 насны хүн ам нэмэгдсэнээс харж болохоор байна. Жил бүр өсөлт, бууралттай байгаа өөрчлөлт нь Монгол Улсын хүн амын ирээдүйн өсөлтийг тодорхойгүй болгож байна.

**Зураг 1: Хүн амын нас хүйсийн сувага, 2010 хүн амын орон сууцны тооллого**



Монгол Улсын хүн ам зүйн бас нэг чухал хүчин зүйл нь хотжилт юм. 2000 оноос Улаанбаатар хотын хүн ам жилд дунджаар 4.2 хувиар өссөн бол хөдөөгийн хүн ам дунджаар 1.9 хувиар буурч, хотжилтийн түвшин эрс нэмэгдсэн. Үүний үр дүнд нийт хүн амд Улаанбаатар хотын хүн амын эзлэх хувь 44, нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувь 68 болжээ. Нийт хүн амд хөдөөгийн хүн амын эзлэх хувь 2000 онд 43 байсан бол 2010 онд 32 хувь болж буурсан. Сүүлийн 10 жилийн туршид хөдөөгийн хүн ам 180,000 хүнээр буурсан байна. 2000-2010 оны хооронд Улаанбаатар хотоос гадна, уул уурхай хөгжиж байгаа таван аймагт л хүн ам өссөн байна. Хотын хүн амын өсөлтийн гол шалтгаан нь хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн болоод байна. 2000-2010 оны хоорондох Улаанбаатар хотын хүн амын өсөлтийн гуравны хоёр хувь нь шилжин ирэлтээс, гуравны нэг хувь нь цэвэр өсөлт (төрөлт нас баралтын зөрүү)-с шалгаалсан байна.

Ажлын байр хайх, боловсрол олох илүү боломж нь хөдөөнөөс хот руу шилжиж буй гол шалтгаан болж байна. Хэдийгээр сурч, боловсорч буй хүн амын тоо нэмэгдэж буй хэдий ч хөдөлмөрийн насны хүн амын өсөлтийг хангах ажлын байр бий болж чадахгүй байна. Эдийн засгийн өсөлт явагдаж байгаа хэдий ч ажлын байрны өсөлт хөдөлмөрийн насны хүн амын өсөлтийг дагаж нэмэгдэж чадахгүй байна. 2010 оны тооллогоор 15 ба түүнээс дээш насны 121,519 хүн тохирсон ажлын байр олдохгүй байгаагаас ажил эрж хайхаа больсон гэсэн бол хөдөлмөрийн насны хүн амын 23,9 хувь буюу 285,635 хүн ажилгүй байгаагийн 164,116 хүн ажил идэвхтэйгээр хайж байгаа гэсэн байна.

Хүн амын хэтийн тооцоогоор хөдөлмөрийн насны хүн амын (15-64 насны хүн ам) тоо ирэх 3 арван жилд өсөх ба хөдөлмөрийн зах зээлд дарамт үзүүлсэн хэвээр байхаар байна. Шинэ ажлын байрны хэрэгцээ ойрын ирээдүйд буурах хандлагагүй байна. Гэхдээ, ажиллах хүчин дэх хүн амын нийт хүн амд эзлэх хувь тогтвортой байх ба харин 65+ дээш насны

хөгшин хүн амын хувийн жин өсөж, 0-14 насны хүүхдийн хувийн жин буурахаар харагдаж байна. Ирэх 30 жилийн хугацаанд 65 ба түүнээс дээш насны хөгшин хүн ам бусад насны бүлгийн хүн амаас хурдтай буюу жилд дунджаар 5 хувиар өсөхөөр байна.

Монгол Улсын хүн ам 2040 он гэхэд дор хаяж 1.4 саяар нэмэгдэж, хүн амын өсөлтийн хувь жилд дунджаар 1.3-1.4 хувиар өсөх төлөвтэй байна. Энэ нь хөгжиж буй орнуудын хувьд хэвийн өсөлтөд тооцогдох боловч зарим чухал бодлогын асуудлууд бий болгох юм. Эхний болон цаашид үргэлжлэх нэг асуудал нь хүн амын насжилт. Өнгөрсөн 20 жилд насжилтын үйл явц удаан явагдаж байсан ба нийт хүн амд эзлэх 60 ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин 6 хүрэхгүй хувь байсан бол 2040 он гэхэд энэ насны хүн ам 16.7 хувийг эзлэхээр байна. Цаашлаад энэ насны хүмүүсийн ихэнх нь эмэгтэйчүүд байхаар байна. Ахимаг настны (80, түүнээс дээш насны хүн ам) хувьд 100 эмэгтэй хүн амд 40 эрэгтэй ноогдохоор байна. Энэ нь Монгол Улсад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс урт насалж байгаагийн үр дагавар юм. Ахмад настныг эрүүл мэнд болон бусад нийгмийн үйлчилгээгээр хангах асуудал тулгарна. Улсын төсөвт эзлэх тэтгэврийн зардал нэмэгдэнэ. Тэтгэврийн нөөцийн сан бүрдүүлэх нь улсын төсвийн дарамтыг бууруулах хэдий ч үүнийг бүрдүүлэхэд тодорхой цаг хугацаа шаардах юм.

Өөр нэг асуудал нь одоогийн ажилгүй байгаа иргэд болон ойрын ирээдүйд ажиллах хүчинд орж ирэх хүмүүст зориулсан шинэ ажлын байр бий болгох явдал. Ахмад хүмүүсийг тэжээх ажиллах хүчинтэй байх нь чухал гэхдээ зөвхөн үр бүтээлтэй ажиллаж буй ажиллагчид л татвар төлж, уг татварын сангаас засгийн газар ахмадуудыг тэжээнэ. Уул уурхайгаас орж ирж буй орлого энэхүү асуудлыг шийдэхэд туслах хэдий ч уул уурхайн салбар шаардлагатай байгаа ажлын байрыг дангаараа бий болгож чадахгүй. Иймд эдийн засгийн салбаруудыг төрөлжүүлж, уул уурхайгаас бусад салбарын ажил

эрхлэлтийг бий болгоход анхаарах нь чухал.

Хөдөө-хотын шилжих хөдөлгөөний өндөр түвшин нь Монгол Улсад тулгамдаж буй асуудлуудын нэг. Хотжилт Улаанбаатар хотод төвлөрөөд байгаа ба хүн амын хурдацтай өсөлттэй холбоотой бий болж буй дэд бүтцийн асуудлыг хот шийдэх асуудалтай тулгараад байна. Хүн амын хэт бөөгнөрөл, агаарын болон усны бохирдлын асуудал, үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлт зэрэг зарим үр дагаврыг нэрлэж болохоор байна. Бодлого боловсруулагч, төлөвлөгчид нийслэлийн ачаалыг багасгахын тулд хотын өсөлтөөс илүү жижиг хотууд руу шилжихэд юу хийх талаар анхаарах хэрэгтэй.

Монгол Улсын хүн ам зүйн өнөөгийн чиг хандлага хөгжлийн үе шатанд сайн тохирсон гэж үзэж болохоор байна. Хэдийгээр нийгмийн үйлчилгээнд зарим дарамт байгаа хэдий ч хүний хөгжилд (эрүүл мэнд боловсролын чанараар хэмжигддэг) ахиц дэвшил гарсан. Гэсэн хэдий ч эдийн засаг өсөн нэмэгдэж буй ажиллах хүчнийг үр бүтээлтэй хөдөлмөр эрхлэлт рүү чиглүүлж чадахгүй байна. Хүн амын насжилт эрчимжиж эхэлсэн тул ирээдүйд хүн амын нөхцөл байдал тийм ч таатай байхгүй. Бодлого боловсруулагчдын зүгээс хүн амын насжилтын үйл явц явагдаж байх үеийн хүний хөгжлийг дээшлүүлэх зөв бодлого авч хэрэгжүүлэх шаардлагатай.